



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/824

Улаанбаатар хот

“Сүхбаатар дүүргийн “Сүхбаатар дэвшил” ОНӨААТҮГ-ын данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын хүнсний хог хаягдал дахин боловсруулах төслийн хөрөнгөөр нийлүүлсэн нийт 92,070,000.0 (ерэн хоёр сая далан мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сүхбаатар дүүргийн “Сүхбаатар дэвшил” ОНӨААТҮГ (Б.Амгалан)-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн “Сүхбаатар дэвшил” ОНӨААТҮГ (Б.Амгалан)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В. Оюумаа* В. ОЮУМАА



1150511090

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2024 оны 10 дугаар сарын 10 - ны өдрийн
 А/324 дугаар тушаалын хавсралт



Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлд авах		Эх үүсвэр
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	
1	Навч хаягдал сорох машин	MAMUT PRO VT	2024	Шинэ	ш	2	46,035,000.0	92,070,000.0	Төслийн хөрөнгө
Нийт бүртгэх хөрөнгийн дүн								92,070,000.0	